



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2016 оны 07 сарын 15 өдөр

Дугаар 11


Номгон

**Төлөөлөгчдийн бүрэн эрхийг  
зөвшөөрөх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 "а" заалт, аймгийн Сонгуулийн хорооны 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 11 дүгээр тогтоолыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 7 дахь удаагийн сонгуулийн анхдугаар хуралдаанаас **ТОГТООХ** нь:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг сонгох сонгуулиар сонгогчдын олонхийн саналыг авч аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчөөр сонгогдсон хавсралтад заагдсан нэр бүхий 41 төлөөлөгчийн бүрэн эрхийг зөвшөөрсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ



Т.ТОМОРБААТАР

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
анхдугаар хуралдааны 2016 оны 07 дугаар  
сарын 15-ны өдрийн 1/1 тогтоолын хавсралт

БАЯНХОНГОР АЙМГИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧ

| №  | Овог нэр                     | Намын харьяалал | Тойрог                  | Эрхэлдэг ажил                                 |
|----|------------------------------|-----------------|-------------------------|---|
| 1  | 2                            | 3               | 4                       | 5   |
| 1  | Долгорсүрэнгийн Мөнхсайхан   | МАН             | Номгон 1-р тойрог       | Их богдын зам ХХК-ний захирал                 |
| 2  | Пүрэвжавын Рэнцэнпэлжээ      | МАН             | Номгон 1-р тойрог       | RMB ХХК-ний захирал                           |
| 3  | Дорж-Очирын Цэрэнхорлоо      | АН              | Эрдэнэмандал 2-р тойрог | Нэгдсэн эмнэлэгт настны эмч                   |
| 4  | Ниржигийн Оюун               | МАН             | Эрдэнэмандал 2-р тойрог | Эрдэнэмандал 2-р багийн Засаг дарга           |
| 5  | Арвингийн Тарва              | АН              | Дуурсах 3-р тойрог      | Дуурсах 3-р багийн Засаг дарга                |
| 6  | Тогтохын Очирбал             | АН              | Дуурсах 3-р тойрог      | Ардчилсан намын хэрэг эрхлэх газрын дарга     |
| 7  | Түмэнхүүгийн Отгонбаатар     | МАН             | Угалз 4-р тойрог        | Баянхонгор-Эрчим хүч ЦТХХК-ний ахлах инженер  |
| 8  | Сангидоржийн Готов           | МАН             | Угалз 4-р тойрог        | Бага шаргалжуут ХХК-ний захирал               |
| 9  | Жамбалын Дулмаа              | АН              | Цагаанчулуут тойрог 5-р | Нэгдсэн эмнэлэгт дотрын их эмч                |
| 10 | Дэмбэрэлийн Ууганцэцэг       | МАН             | Цагаанчулуут тойрог 5-р | Ажилгүй                                       |
| 11 | Дашравдангийн Идэрханд       | АН              | Гэгээн шавь 6-р тойрог  | Гэгээн шавь 6-р багийн Засаг дарга            |
| 12 | Батсүрэнгийн Нацагдорж       | МАН             | Гэгээн шавь 6-р тойрог  | Хонгор дент шүдний эмнэлгийн захирал          |
| 13 | Дамдинсүрэнгийн Жаргалсайхан | АН              | Цахир 7-р тойрог        | Баянхонгор аймгийн Засаг дарга                |
| 14 | Энэбишийн Гүнжинлхам         | АН              | Цахир 7-р тойрог        | Энхбүрд өрхийн эрүүл мэндийн төвийн их эмч    |
| 15 | Ламзавын Баасанбат           | АН              | Шаргалжуут тойрог 8-р   | Шаргалжуут тосгоны эрүүл мэндийн төвийн дарга |
| 16 | Батнасангийн Батсуурь        | МАН             | Есенбулаг тойрог 9-р    | Хувиараа                                      |
| 17 | Дашийн Ганбаатар             | АН              | Өлзийт сум 10-р тойрог  | Баялаг-Орд ХХК-ний гүйцэтгэх захирал          |
| 18 | Готовын Хоролсүрэн           | МАН             | Өлзийт сум 10-р тойрог  | Нэгдсэн эмнэлэгт зөвлөх эмч                   |
| 19 | Эрдэнэ-Очирын Цэнд           | МАН             | Жинст сум 11-р тойрог   | Нэгдсэн эмнэлэгт халдвартын эмч               |

| 1  | 2                          | 3   | 4                           | 5  |
|----|----------------------------|-----|-----------------------------|--|
| 20 | Дэндэвийн Ширмэн           | АН  | Богд сум 12-р тойрог        | Баянхонгор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга   |
| 21 | Жамцын Хүрэлбаатар         | АН  | Баянлиг сум 13-р тойрог     | Зоригт болд ХХК-ний захирал                              |
| 22 | Оргодолын Мөнхбат          | АН  | Баянлиг сум 13-р тойрог     | Баянлиг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга        |
| 23 | Гончигдоржийн Батжаргал    | МАН | Баянговь сум 14-р тойрог    | МАН-ын дэд дарга   |
| 24 | Баасангийн Батбаяр         | МАН | Баян-Өндөр сум 15-р тойрог  | МИСС ХХК-ний дэд ерөнхийлөгч                             |
| 25 | Насанбатын Баярсайхан      | МАН | Шинэжинст сум 16-р тойрог   | Ембүү цахир хоршооны дарга                               |
| 26 | Намсрайн Шагдарсүрэн       | МАН | Баянцагаан сум 17-р тойрог  | Дэлхийн зөн ОУБ-ын орон нутгийн хөгжлийн ажилтан         |
| 27 | Полоожийн Дашзэвэг         | АН  | Баянцагаан сум 17-р тойрог  | Баянцагаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч |
| 28 | Тамжаагийн Бат-Очир        | АН  | Баацагаан сум 18-р тойрог   | Баянхонгор трейд центр ХХК-ний гүйцэтгэх захирал         |
| 29 | Цэвэлсүрэнгийн Энхтөр      | МАН | Бөмбөгөр сум 19-р тойрог    | ХҮДС-ийн сургалт хариуцсан менежер                       |
| 30 | Жамьянсүрэнгийн Алтанцэцэг | МАН | Бууцагаан сум 20-р тойрог   | Бууцагаан сумын МАН-ын дарга                             |
| 31 | Бэгзсүрэнгийн Энхтүвшин    | МАН | Бууцагаан сум 20-р тойрог   | Төгий такс ТЭМЗ ХХК-ний үүсгэн байгуулагч                |
| 32 | Цэен-Ойдовын Сэмжиддорж    | АН  | Хүрээмарал сум 21-р тойрог  | Хувиараа   |
| 33 | Магваны Мөнхбат            | МАН | Баянбулаг сум 22-р тойрог   | Баянхонгор-Хаан даатгал захирал                          |
| 34 | Цэдэндоржийн Энхболд       | МАН | Гурванбулаг сум 23-р тойрог | Ногоон алт төсөл зохицуулагч                             |
| 35 | Самбуугийн Амармөнх        | МАН | Заг сум 24-р тойрог         | Авто тээврийн төв инженер                                |
| 36 | Дандийн Мөнхжаргал         | МАН | Жаргалант сум 25-р тойрог   | Хувиараа   |
| 37 | Цагааны Отгонбаяр          | МАН | Галуут сум 26-р тойрог      | Хувиараа   |
| 38 | Сосорбарамын Цэгмид        | МАН | Галуут сум 26-р тойрог      | Улаанбаатар хот ДХШ-ын ажилтан                           |
| 39 | Жамбалдоржийн Пүрэвсүрэн   | АН  | Баян-Овоо сум 27-р тойрог   | Баян-Овоо сумын Засаг дарга                              |
| 40 | Цэрэндоржийн Төмөрбаатар   | МАН | Эрдэнэцогт сум 28-р тойрог  | Эрдэнэцогт сумын Засаг дарга                             |
| 41 | Эрдэнээгийн Энхбат         | МАН | Эрдэнэцогт сум 28-р тойрог  | -  |



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 07 сарын 15 өдөр

Дугаар

1/2

Номгон


Хурлын даргыг сонгох,  
чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 7 дахь удаагийн сонгуулийн анхдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргыг сонгох санал хураалтад оролцсон төлөөлөгчдийн 100 хувийн санал авсан Цагааны Отгонбаярыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргаар сонгосугай.

2. Бүрэн эрх нь дуусгавар болж байгаатай холбогдуулан Дэндэвийн Ширмэнг 2016 оны 07 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ



Ц.ТӨМӨРБААТАР



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 07 сарын 15 өдөр

Дугаар

1/3

Номгон

Хурлын Тэргүүлэгчдийг сонгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 7 дахь удаагийн сонгуулийн анхдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тоог 11 байхаар тогтоосугай.

2. Хуралд оролцсон төлөөлөгчдийн олонхийн санал авсан төлөөлөгч Ц.Отгонбаяр, Ж.Алтанцэцэг, Н.Оюун, М.Мөнхбат, Ц.Төмөрбаатар, Э.Энхбат, Ц.Энхтөр, Б.Нацагдорж, Н.Баярсайхан, Т.Отгонбаатар, П.Рэнцэнпэлжээ нарыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчээр сонгосугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

116913



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2016 оны 07 сарын 15 өдөр

Дугаар 1/4

Номгон

Аймгийн Засаг даргад  
нэр дэвшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 "г", 26 дугаар зүйлийн 26.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 7 дахь удаагийн сонгуулийн анхдугаар хуралдаанаас **ТОГТООХ** нь:

1. Аймгийн Засаг даргад нэр дэвшүүлэх санал хураалтад оролцсон төлөөлөгчдийн олонхийн буюу 61 хувийн саналыг авсан Гончигдоржийн Батжаргалыг аймгийн Засаг даргад нэр дэвшүүлсүгэй.

2. Аймгийн Засаг даргад нэр дэвшсэн Гончигдоржийн Батжаргалыг аймгийн Засаг даргаар томилж өгөхийг Монгол Улсын Ерөнхий сайдад уламжлан хүссүгэй.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

116007



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 07 сарын 15 өдөр

Дугаар 1/5

Номгон

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 7 дахь удаагийн сонгуулийн анхдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, аймгийн нийгэм эдийн засгийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг шалгаж, дүгнэлт гарган хурлын хуралдаанаар хэлэлцүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Батсуурь-Төлөөлөгч

Гишүүд:

Ц.Энхтөр – Тэргүүлэгч, Төлөөлөгч

С.Готов-Төлөөлөгч

Ж.Хүрэлбаатар-Төлөөлөгч

Ц.Сэмжиддорж-Төлөөлөгч

Э.Энхбат- Тэргүүлэгч, Төлөөлөгч

М.Мөнхбат- Тэргүүлэгч, Төлөөлөгч

2. Ажлын хэсгийн санал дүгнэлтийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын II хуралдаанд хэлэлцүүлэхийг ажлын хэсэг /Б.Батсуурь/-т даалгасугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР

116717